



Долоо хоног тутмын хэвлэл  
2015 оны 11 дүгээр сарын 02  
№41 /902/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

1790

**Анхны ардчилсан сонгууль  
болж байнгын ажиллагаатай  
парламент байгуулагдсаны  
25 жилийн ойг тохиолдуулан  
өршөөл үзүүлэх тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай**

**Монгол Улсын Их  
Хурлын тогтоол**

1791

**Монгол Улсын батлан  
хамгаалах бодлогын үндсийг  
батлах тухай**



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

470.	Протокол соёрхон батлах тухай	1790
471.	Протокол соёрхон батлах тухай	1790
472.	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1790

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

473.	Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай	Дугаар 85	1791
474.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 89	1801
475.	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 90	1802
476.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 91	1807

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

477.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 165	1807
478.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 166	1808
479.	Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 167	1808
480.	Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг томилох тухай	Дугаар 168	1811

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

481.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 06	1811
------	--	-----------	------



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2003 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 10 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **АНХНЫ АРДЧИЛСАН СОНГУУЛЬ БОЛЖ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ БАЙГУУЛАГДСАНЫ 25 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Насанд



хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах” гэсний өмнө “Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах /Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйл/,” гэж, “Танхайрах” гэсний өмнө “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 147.2 дахь хэсэг/,” гэж, “181.2” гэсний дараа “, 181.3” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “Зандалчлах” гэсний өмнө “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах /Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэг/,” гэж, “гэмт хэрэг үйлдсэн” гэсний өмнө “, Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах /Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл/,” Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх /Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйл/,” Хээл хахууль авах /Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйл/,” Хууль бусаар хөрөнгөжих /Эрүүгийн хуулийн 270<sup>1</sup> дүгээр зүйл/,” Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах /Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйл/” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 5.1, 9.1-д” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Энэ хуулийн 5.1, 9.1.3-т” гэснийг “Энэ хуульд ялаас өршөөн хасах болон өршөөлд хамааруулахгүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах /Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйл/,” гэснийг, “147.2,” гэснийг, “Танхайрах /Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсэг/,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 10 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын батлан хамгаалах  
бодлогын үндсийг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1998 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
85 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ  
БОДЛОГЫН ҮНДЭС**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

1.2.Монгол Улсын батлан хамгаалах бодлогын зорилго нь аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс ангид байж, улсыг батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах явдал мөн.

1.3.Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Засгийн газар хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хурал хяналт тавина.

1.4.Энэ бодлогын улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн чиглэлийн хэрэгжилтийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд зохион байгуулна. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

**Хоёр.Батлан хамгаалах тогтолцоо**

2.1.Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар



тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн.

2.2.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно.

2.3.Монгол Улс орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ:

2.3.1.орон нутгийн хамгаалалт нь Монгол Улсын өөрийгөө хамгаалах стратегийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд батлан хамгаалах талаар төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хэрэгжүүлэх олон талт нэгдмэл арга хэмжээ мөн.

2.3.2.орон нутгийн хамгаалалтын зарчим, удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, дэд бүтэц нь дайчилгааны сургалт явуулах болон нөөц бүрдүүлэх тогтолцоотой уялдсан байна.

2.3.3.орон нутгийн хамгаалалтын удирдлагыг нутгийн захиргааны бүх шатны байгууллага төрийн цэргийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах үндсэн нэгж нь Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб байна.

2.3.4.орон нутгийн хамгаалалтын харилцааг Монгол Улсын хуулиар зохицуулна.

2.4.Зэвсэгт хүчин нь үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллын тогтолцоо мөн:

2.4.1.Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлнэ.

2.4.2.зэвсэгт хүчинд холбогдох харилцааг Монгол Улсын хуулиар зохицуулна.

2.5.Монгол Улс нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог эдийн засгийн төлөв байдал, зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн бүрдүүлнэ:

2.5.1.дайчилгааны тогтолцоонд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны материаллаг болон санхүүгийн



нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээг хамааруулна.

2.5.2.Монгол Улс дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөтэй байна.

2.5.3.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр хуульд заасан дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэх урьдчилсан бэлтгэлтэй байна.

2.5.4.дайчилгааны бэлтгэлийг хангах, дайчилгаа явуулах харилцааг Монгол Улсын хуулиар зохицуулна.

2.6.Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна.

2.7.Батлан хамгаалахын удирдлагыг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.8.Батлан хамгаалахын иргэний болон цэргийн удирдлагын харилцааг хуулиар зохицуулна.

2.9.Батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ хийх үндсэн үүргийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

### **Гурав.Батлан хамгаалах бодлогын улс төрийн чиглэл**

3.1.Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох бөгөөд гадны зэвсэгт түрэмгийллийн эсрэг цэргийн хүчийг ашиглана.

3.2.Монгол Улс гадны цэргийн аюулаас сэрэмжлэх бодлогоо дараах зарчимд нийцүүлнэ:

3.2.1.хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх;



3.2.2.цэргийн хүч хэрэглэх болон хэрэглэхээр заналхийлэхийг зөрчил, маргааныг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийг үл зөвшөөрөх;

3.2.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцох;

3.2.4.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй;

3.2.5.нутаг дэвсгэрээ хөрш болон бусад орны эсрэг чиглэсэн цэргийн үйл ажиллагаанд ашиглуулахгүй, үй олноор хөнөөх зэвсгээс ангид байлгах;

3.2.6.гадны зэвсэгт түрэмгийлэлд өртөхөөс бусад тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байх;

3.2.7.хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх;

3.2.8.үй олноор хөнөөх зэвсгийн тархалтыг хязгаарлах, олон улсын терроризмтой тэмцэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх.

3.3.Монгол Улс дараах нөхцөл байдлыг өөрийн эсрэг чиглэсэн зэвсэгт түрэмгийлэл гэж үзнэ:

3.3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдан довтлох, цөмрөн орох;

3.3.2.хилийн гаднаас улсын болон цэргийн объектод зэвсгийн хүчээр цохилт хийх;

3.3.3.гадаад улсын цэргийн хүчин Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах, дамжин өнгөрөхдөө энэ тухай Монгол Улсын хуулийг зөрчих;

3.3.4.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газар ашиглаж байгаа гадаадын этгээд ашиглаж байгаа газраа зэвсэгт түрэмгийллийн зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах;

3.3.5.тусгайлан бэлтгэгдэж, зэвсэглэсэн хүмүүсийг зохион байгуулалттайгаар Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт террорист ажиллагаа явуулах, нийтийг хамарсан үймээн самуун дэгдээх;





3.3.6. аль нэг улсын дотоодын зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд Монгол Улсын хилийг зөрчих, цөмрөн орох.

3.4. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, хүн ам, иргэдийн аюулгүй байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн улс болон улс бус этгээд тэдний түрэмгийллийн хамсаатныг дайсан гэж үзнэ.

3.5. Гадны цэргийн аюул учирсан нөхцөлд зэвсэгт хүчин түрэмгийллийг саатуулан няцааж, улс орны удирдлагад улс төр, дипломатын идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлнэ.

### **Дөрөв. Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл**

4.1. Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэнэ.

4.2. Монгол Улсын эдийн засгийн бодлого, төлөвлөлт, стратегийн ач холбогдолтой уул уурхай, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, гадны хөрөнгө оруулалт, ажиллах хүчийг ашиглах үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлж байна.

4.3. Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Монгол Улсын батлан хамгаалах хэрэгцээг хангах эдийн засгийн чадавхыг бүрдүүлнэ. Батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.

4.4. Орон нутгийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон төсвийг тухайн орон нутгийн төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.5. Монгол Улсын батлан хамгаалах нөөцийн менежмент, түүнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, батлан хамгаалах зориулалт бүхий материаллаг нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх тогтолцоог төгөлдөржүүлнэ.

4.6. Батлан хамгаалахын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжид төрөөс дэмжлэг үзүүлнэ. Цэргийн зарим нэр төрлийн эд хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, засвар үйлчилгээ хийх, худалдан авах бодлого баримтална.

4.7. Зэвсэгт хүчний зэвсэглэлийг үе шаттай шинэчилж байх уян хатан тогтолцоо бүрдүүлнэ. Цэргийн зэвсэг, техник худалдан авахад



зориулан батлан хамгаалах зардлын тодорхой хэсгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байна.

4.8.Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн бусад орон, олон улсын байгууллагаас цэрэг-техникийн дэмжлэг, тусалцаа авч байх чиглэлийг баримтална.

4.9.Цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусгаж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

### **Тав.Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэл**

5.1.Монгол Улсын хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс мөн.

5.2.Бүс нутгийг хөгжүүлэх, хүн амыг амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

5.3.Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ.

5.4.Иргэдийн цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.5.Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно. Цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаагагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Төрийн албанд анх орж байгаа иргэнд цэргийн алба хаасан байх шаардлага тавина.

5.6.Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.7.Цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Зургаа.Батлан хамгаалах бодлогын эрх зүйн чиглэл**

6.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн гаргасан энэ бодлого нь батлан



хамгаалах салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндэс бөгөөд олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлахад харгалзана.

6.2.Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана.

6.3.Зэвсэгт хүчний ардчилсан удирдлагыг бэхжүүлж, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг төгөлдөржүүлнэ.

6.4.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

6.5.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх журмыг хуулиар тогтооно.

### **Долоо.Төрийн цэргийн байгуулал**

7.1.Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ. Дайны байдлын үед хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэнэ.

7.2.Зэвсэгт хүчин Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг болон төрөл мэргэжлийн бусад цэргээс бүрдэнэ.

7.3.Тайван цагт хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно.

7.4.Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг даган мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.5.Төрийн цэргийн номлолыг тусгайлан боловсруулж мөрдөнө.

7.6.Төрийн цэргийн байгууллыг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төр, нийгмийн байгууллын үндэс, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

7.7.Төрийн цэргийн байгууллын удирдлага нь улс төрийн дээд удирдлага, төрийн захиргааны удирдлага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагаас бүрдэх бөгөөд эдгээр удирдлагыг дараах байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ:

7.7.1.төрийн цэргийн байгууллын улс төрийн дээд удирдлагыг Монгол Улсын Их Хурал;



7.7.2.төрийн цэргийн байгууллын төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

7.7.3.төрийн цэргийн байгууллын цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб.

7.8.Цэргийн мэргэжлийн дээд удирдлага гэж цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтийг хангах, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагуудын харилцан ажиллагаа, байлдааны бэлэн байдлыг хангах хамтарсан сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөлтийг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, цэргийн байгууллагын зэвсэглэл, техникийн харилцан уялдааг хангах, холбоо мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн удирдлагын цогц үйл ажиллагааг ойлгоно.

7.9.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хилийн ба дотоодын цэргийн командлагч, онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч хамтран хэрэгжүүлэх бөгөөд түүний уялдаа холбоог хангах ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хариуцна.

7.10.Төрийн цэргийн байгуулал дараах нийтлэг зарчимд тулгуурлана:

7.10.1.төрийн удирдлага, хяналтад байх;

7.10.2.нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх;

7.10.3.хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх;

7.10.4.бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл нь гүйцэтгэх үүрэгтээ зохицсон байх;

7.10.5.хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх бэлтгэлтэй байх.

### **Найм.Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэл**

8.1.Зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах үндсэн үүрэг хүлээнэ.

8.2.Зэвсэгт хүчин тайван цагт дараах үүрэг хүлээнэ:

8.2.1.эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах;



8.2.2.агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах;

8.2.3.улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

8.2.4.гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах;

8.2.5.байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх;

8.2.6.дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах, хүн амыг цэргийн хэрэгт сургахад дэмжлэг үзүүлэх;

8.2.7.улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

8.2.8.энхийг дэмжих ажиллагаанд оролцох;

8.2.9.улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх;

8.2.10.хуулиар тогтоосон бусад үүрэг.

8.3.Зэвсэгт хүчнийг дараах чиглэлээр хөгжүүлнэ:

8.3.1.зэвсэгт хүчний төрөл, төрөл мэргэжлийн цэргийн зохистой харьцааг батлан хамгаалах хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн боломжийг үндэслэн тогтоох;

8.3.2.монгол цэргийн өв уламжлал, цэргийн урлагийг сэргээн судалж, хөгжүүлэх;

8.3.3.зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээ биелүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, терроризмтой тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх;

8.3.4.байлдааны зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинжлэх ухаан, технологийн хөгжил, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн зэвсэгт хүчний шаардлагад нийцүүлэн шинэчлэх;

8.3.5.цэргийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх тогтолцоог төгөлдөржүүлэх;

8.3.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцох бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх;



8.3.7.цэргийн удирдлага, холбоо, мэдээллийн хэрэгслийг шинэчилж, аюулгүй байдлыг хангах, кибер халдлагатай тэмцэх бүтэц бий болгох;

8.3.8.хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгож, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын баталгааг бүрдүүлэх;

8.3.9.орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололт, инновацийг цэргийн хэрэгт нэвтрүүлэх;

8.3.10.цэргийн сургалтын тогтолцоог цэргийн урлаг, зэвсэглэл, техник, технологийн дэвшил, гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн боловсронгуй болгох;

8.3.11.дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх, дээд боловсролтой залууст цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх;

8.3.12.зэвсэгт хүчинд түргэн байрлах хүчний нэгжийг бий болгож хөгжүүлэх;

8.3.13.батлан хамгаалах мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, С.Батболд, Н.Батцэрэг, М.Батчимэг нарын 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар  
хот

### **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрын хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталж, улсын тусгай хэрэгцээнд авсугай.

2.“Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай ”Монгол Улсын Их Хурлын 2009 оны 37 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Элчин сайдын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчийн газар болон “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 52 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яамны газрын хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3.Гадаад улсын дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газартай харилцан адил байх зарчмыг баримтлан газар ашиглуулах гэрээ байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2009 оны 37 дугаар тогтоолын хавсралтын 1.1, 2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар улсын тусгай хэрэгцээнд авсан Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яамны газрын хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
90 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ГАДААД УЛСЫН ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН БОЛОН КОНСУЛЫН ГАЗАР,  
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ ОЛГОСОН  
ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ, ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ,  
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ**

№	Эргэлтийн цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Хаяг, байршил	Талбайн хэмжээ /м.кв/
		47	55	29.7153	106	55	39.2256		
1	1	47	55	29.7153	106	55	39.2256	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бүгд Найрамдах Франц Улсын соёлын төв	1530.57
	2	47	55	29.8455	106	55	41.0723		
	3	47	55	30.083	106	55	41.655		
	4	47	55	30.4206	106	55	41.61		
	5	47	55	30.427	106	55	41.6524		
	6	47	55	30.886	106	55	41.556		
	7	47	55	30.7222	106	55	39.0666		
	8	47	55	30.0411	106	55	41.0292		
2	1	47	55	27.659	106	54	56.142	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Европын Холбооны төлөөлөгчийн газар	1438.13
	2	47	55	27.566	106	54	55.077		
	3	47	55	29.659	106	54	54.669		
	4	47	55	29.73	106	54	55.646		
	5	47	55	29.651	106	54	55.743		





3	1	47	55	36.874	106	55	47.567	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам	28239.29
	2	47	55	37.97	106	55	47.382		
	3	47	55	37.926	106	55	46.808		
	4	47	55	38.891	106	55	46.645		
	5	47	55	39.856	106	55	46.483		
	6	47	55	41.786	106	55	46.158		
	7	47	55	43.825	106	55	45.814		
	8	47	55	43.827	106	55	45.853		
	9	47	55	44.06	106	55	49.451		
	10	47	55	44.146	106	55	50.636		
	11	47	55	44.704	106	55	50.609		
	12	47	55	44.777	106	55	52.553		
	13	47	55	37.091	106	55	52.536		
4	1	47	53	29.39	106	56	8.01	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Бүгд Найрамдах Казахстан Улсын Элчин сайдын яам	11999.28
	2	47	53	27.2229	106	56	4.5501		
	3	47	53	26.0302	106	56	2.8491		
	4	47	53	30.108	106	56	0.764		
	5	47	53	30.9089	106	56	6.3387		
Нийт									43207.27

Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
90 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД СУУГАА БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД  
УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН  
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ БОЛОН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ, ЭРГЭЛТНИЙ  
ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ**

№	Эргэлтийн цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Хаяг, байршил	Талбайн хэмжээ /м.кв/
		47	54	12.031	106	55	14.5093		
1	1	47	54	12.031	106	55	14.5093	Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бүгд Найрамдах Солонгос Улсын Элчин сайдын яам	9973.07
	2	47	54	14.9878	106	55	14.3365		
	3	47	54	15.1383	106	55	14.4437		
	4	47	54	15.2352	106	55	14.6366		
	5	47	54	15.2997	106	55	15.3179		
	6	47	54	15.4297	106	55	19.1182		
	7	47	54	12.1917	106	55	19.3364		
	1	47	55	31.017	106	54	59.024		
	2	47	55	30.049	106	54	59.185		



3	47	55	27.96	106	54	59.609	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчийн газар	7228.3
	4	47	55	27.659	106	56.142		
	5	47	55	29.651	106	55.743		
	6	47	55	29.73	106	55.646		
	7	47	55	29.659	106	54.669		
	8	47	55	30.387	106	54.527		
	1	47	55	10.157	106	20.928		
	2	47	55	10.09	106	19.883		
	3	47	55	9.549	106	18.961		
	4	47	55	9.52	106	18.585		
3	5	47	55	8.529	106	18.647	Баянзүрх дүүргийн 15 дугаар хороонд байрлах Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Элчин сайдын яам	2414.62
	6	47	55	8.317	106	19.095		
	7	47	55	8.434	106	21.228		
	8	47	55	8.61	106	21.149		
Нийт								19615.99



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар  
хот

### Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлэгдсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Могнооны Болормааг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3.8 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хабыейн Жардемханыг Баян-Өлгийн аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 10 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 167

Улаанбаатар  
хот

### Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан нэр бүхий хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны  
10 дугаар сарын 29-ний өдрийн 167 дугаар  
зарлигийн хавсралт

Нэг. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1. Дамцагдоржийн Бүрнээг Булган аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,



2.Цэнджавын Байгалмааг Сэлэнгэ аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

3.Цогийн Одмаа, Цэнд-Аюушийн Мөнхзул, Лувсандоржийн Өлзийсайхан нарыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.

Хоёр. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1.Баяраагийн Батаа, Цэнд-Очирын Мөнх-Эрдэнэ нарыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

2.Нямжавын Баярмаа, Буянтын Дуламсүрэн нарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

3.Чинзоригтын Мөнхтуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.

Гурав. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1.Чадраабалын Жаргаланг Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

2.Нэргүйн Хангал, Баяраагийн Баярмаа, Хонгорын Энхзаяа, Багшарын Азбаяр, Даваадоржийн Энхцэцэг, Чулуунбаатарын Нямсүрэн нарыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

3.Ганболдын Амаржаргалан, Дашдоржийн Золзаяа, Ийгэрийн Амартөгс, Хувсааралын Дашдэчмаа, Дамдингийн Батцэцэг нарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

4.Авуталивын Жархынгүлийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

5.Чойжоогийн Баярцэнгэлийг Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,



6.Отгоогийн Одончимэгийг Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

7.Цэндийн Наранчимэгийг Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

8.Лхагвасүрэнгийн Хишигдэлгэрийг Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

9.Төмөрийн Балжиннямыг Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

10.Адшаагийн Үүрийнтуяаг Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

11. Аюурзанын Энхтөрийг Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

12. Цамбын Эрдэнэзууг Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

13. Батсайханы Мөнхзулыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

14. Дугарсүрэнгийн Алтантуулыг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

15. Лувсанравжаагийн Дэлгэрцэцэгийг Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

16. Бадарчийн Маринаг Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд,

17. Гал-Эрдэнийн Даваахүүг Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.

Дөрөв. Сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд:

1. Батжаргалын Нармандахыг Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд.



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 10 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 168

Улаанбаатар  
хот

### Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бийцээгийн Үнэнбатыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 12.20 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан /илтгэгч/, Т.Лхагваа, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцож, мэдээлэл гаргагч иргэн А.Базар оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Монгол





Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалт, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан үзэж, эцэслэн шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” 55 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

***Нэг.Иргэн А.Базар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэг хандаж дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ:***

“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ...”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд “хууль зүйн асуудлаар аман болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх; хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянах, батлах; иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх; нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх, үйл ажиллагааг явуулах”-ыг мэргэжлийн үйл ажиллагааны төрөл болохыг нь хууль тогтоогч хүлээн зөвшөөрч, хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, яллах дүгнэлт, шүүхийн шийдвэр, хуулийн төсөл гэх мэт хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийг боловсруулах ажиллагаанд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүн, шүүгч, прокурорын туслахын үйл ажиллагааг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл болохыг хүлээн зөвшөөрсөн боловч субъектынх нь хувьд тэдгээр хүмүүсийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн гэдэгт хамруулаагүй байна. Эрх зүйч, хуульч нь татварын асуудлаар



хуулийн этгээдүүдэд хууль зүйн зөвлөгөө өгдөг, татварын байгууллагад төлөөлөх зэрэг үйл ажиллагааг эрхэлж буй нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэгэн төрөл болохыг хуулийн 24 дүгээр зүйлээр хуульчилсан боловч, хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу тухайн иргэнийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн бус мэргэжлийн дадлага эрхэлсэн гэх ойлголтод хамруулан хуульчилсан байна.

Орчин үед хуульч нь иргэн, хуулийн этгээдийг шүүхэд төлөөлөх ажиллагаа буюу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхээс гадна хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг өргөнөөр эрхэлж байна. Иймд татвар, банк, даатгал, уул уурхай гэх мэт нарийн төвөгтэй салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудад хууль зүйн зөвлөгөө өгч байгааг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж үзэхгүй байх үндэслэлгүй бөгөөд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчих юм. Мэргэжлийн үйл ажиллагаа гэх ойлголтыг зөвхөн шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр хязгаарлах бус эдгээр үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах мэргэжлийн үйл ажиллагаа гэж үзэх үндэслэлтэй.

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар дүгнэлтээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосон.

Гэвч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт нь ерөнхий заалт боловч Үндсэн хуулийн зөрчил бүхий, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хязгаарлан тодорхойлсон нарийвчилсан заалт болох Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг хүчин төгөлдөр байна. Түүнчлэн 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад "... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, ... болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг ” гэсэн хэсэг нэмж оруулсан байна.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ...”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж



болно.” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

**Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

“1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй.” гэж зааснаас бусдаар тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг тодорхой хугацаатай эрхэлсний дараа “хуульч”-д тооцогдох ямар нэгэн зохицуулалт байхгүй болно. Мэдээлэлд дурдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “ ... гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ...” гэснийг зөрчсөн асуудал Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх хэсэгт байхгүй байна.

2. Хуульч нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцож, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлж, хүний эрхийг хангах баталгаа болохын хувьд түүний мэргэжлийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлох нь төрийн үүрэг юм. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...” гэснийг зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй бөгөөд харин ч ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулж өгсөн гэж үзэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэсэн байх ба Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай асуудалд холбогдуулан тайлбар гаргаагүй байна.

**Гурав.** Дээрх маргааныг Цэцийн дунд суудлын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэх явцад Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн



ерөнхий зөвлөл, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагаас холбогдох тайлбар, баримт гаргуулж авсан болно.

***Дөрөв. Үндсэн хуулийн цэц 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа энэхүү маргааныг хэлэлцэж 08 дугаар дүгнэлт гаргажээ.***

**Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:**

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 06 дугаар дүгнэлтийг хэлэлцэж хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурал 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, ... болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн хэсэг нэмж Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... мэргэжлээрээ ажилласан...” гэснийг тодотгосон нь Үндсэн хуулийн маргаан бүхий зөрчлийг арилгасан гэж үзэх үндэслэлгүй байна гэж заасан.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэгт хуульчийн мэргэжлийн дадлагад хамаарах ажил, албан тушаалыг хуульчилсан нь хуульд заасан тодорхой болзол, шалгуурыг хангасан иргэн хуульчийн шалгалтад орох эрх үүсэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ гэж үзэхээр байх тул Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй.” гэснийг, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.” гэжээ.

**Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:**

“1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй.”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил



мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй.”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.” гэсэн байна.

***Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцээд “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” 55 дугаар тогтоол гаргасан байна. Уг тогтоолд:***

“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй.”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

***Зургаа. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... Цэцийн дүгнэлтийг дараах үндэслэлээр хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Үүнд:



1. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 06 дугаар дүгнэлтийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрч, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг;” гэсэн 3.1.3 дахь заалтыг 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар ““хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” ойлгохоор гэж өөрчлөн найруулсан.

Гэтэл Үндсэн хуулийн цэц 2015 оны 02 дугаар тогтоолоороо “... Монгол Улсын Их Хурал 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, ... хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг” гэсэн хэсэг нэмж оруулснаараа Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... мэргэжлээрээ ажилласан ...” гэснийг тодотгосон нь Үндсэн хуулийн маргаан бүхий зөрчлийг арилгасан гэж үзэх үндэслэлгүй байна” гэж үзэж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаас өмнө дагаж мөрдөж байсан, тухайн үед үйлчлэхээ байсан заалт болох “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж, шүүн таслах ажиллагаанд оролцох болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэхийг;” гэснийг хүчингүй болгосон байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар тогтоол гарах үед Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн 3.1.3 дахь заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж байсан болно.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт орсон өөрчлөлтийн хөдөлгөөнийг тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эх



бичвэрт тэмдэглэхдээ өөрчлөлт орсон зүйл, хэсэг заалтыг дарж, түүний оронд тухайн өөрчлөлтөөр өөрчлөгдсөн буюу өөрчлөн найруулагдсан зүйл, хэсэг, заалтыг оруулдаг.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3 дахь заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр бус харин техникийн алдаа гарсны учир хууль зүйн хувьд залруулах шаардлага үүснэ гэж үзэж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэх ойлголтыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхойлж хуульчилж өгсөн нь тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт юм. Хуульч нь бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх замаар хүний эрхийг баталгаажуулах, шүүх эрх мэдлийн байгууллагад бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байдлаар шүүн таслах ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий мэргэжилтний хувьд түүнд тавигдах шаардлага, шалгуурыг тогтоох нь төрийн үүрэг мөн.

3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлаагүй бөгөөд харин ч иргэн бүрийн Үндсэн хуулиар хамгаалагдсан шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэдгийг тодорхойлсон заалт юм. Хуульд заасан шаардлагыг биелүүлсэн хүн бүр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нь нээлттэй бөгөөд үүнийг хуулиар хязгаарласан асуудал огт байхгүй болно.

4. Дан ганц хуульч мэргэжилд ч бус тодорхой төрлийн мэргэжлүүдэд хуулиар болон дүрэм журмаар ийм төрлийн шаардлага тавьдаг. Тухайлбал, анагаах ухааны их сургууль төгссөн их эмч мэргэжилтэй хүн сургуулиа төгссөн ч хүн эмчлэх эрхгүй бөгөөд дахин суралцаж лиценз авснаар түүний эмчлэх эрх нээлттэй болдог. Гэтэл тэднээс Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан гэсэн асуудал огт хөндөгддөггүй бөгөөд тийм ч байх нь зайлшгүй юм. Хуульчийн мэргэжил үүнтэй яг адил болохын хувьд хууль тогтоогчид хуульд тавигдах тусгай шаардлагуудыг хуулиар тогтоож өгсөн. ..." гэжээ.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн



3.1.3 дахь заалтаар “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэсэн ойлголтыг тодорхойлохдоо хэт явцууруулан хуульчилж хууль зүйн салбарт мэргэжлээрээ ажиллаж байгаа иргэдийн Үндсэн хуулиар баталгаажуулсан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх ба Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 06 дугаар дүгнэлтийг хэсэгчлэн хүлээн авч, 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, ... болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн хэсэг нэмж шинэчлэн найруулсан нь Үндсэн хуулийн зөрчлийг арилгасан гэж үзэх хангалттай үндэслэл болохгүй байх тул уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг бүхэлд нь хүчингүй болгох үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн 08 дугаар дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 55 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:**

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” гэж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл шүүхэд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван





зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй. ...”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” 55 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**П.ОЧИРБАТ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**Т.ЛХАГВАА**

**Д.СУГАР**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.СОЛОНГО**

**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medelel@parliament.mn](mailto:turiin_medelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2

**Индекс: 14003**